| ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ТАМИРААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжил тэлтийн хувь |
| 1 | ***Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, давахыг бэхжүүлэх*** | | | | | | |
| 1 | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, эрх зүйн | Үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | **1.** Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, | **1.** Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулахаар Сангийн яаманд хүргүүлэх. | **1.** “Ажлын хэсэг байгуулах тухай” ГЕГ-ын даргын 2023 оны №А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд орж ажилласан.<br>Энэ хугацаанд 2021-2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн.<br>Мөн гаалийн байгууллагын чиг үүрэгт шинээр орсон хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын асуудлыг шинээр бүлэг болгон Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.<br>Түүнчлэн гадаад улсуудын жишиг, УИХ-ын гишүүдтэй хийсэн уулзалт дээр өгсөн чиглэлийн дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлд нэгтгэн найруулав.<br>Гаалийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн найруулсан.<br>ДГБ-ын багц стандарт, гарын авлага, бусад орны хууль тогтоомжуудыг судалж, Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенци /Киото контенци/ болон түүнд оруулах өөрчлөлтүүд, ДГБ-аас өгсөн зөвлөмжүүдтэй танилцсан. | Биелэлт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн. Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд | | Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, гаалийн газар хороодоос ирсэн саналуудтай нэгбүрчлэн танилцаж, ирсэн саналуудыг бүлэглэн хуулийн төслийн холбогдох хэсгүүдэд тусган, хүлээн авах боломжгүй саналуудын шалтгааныг тэмдэглэн ажиллав.<br><br>Хуулийн төслийн холбогдох заалтуудыг боловсруулах үед ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, гарч буй хүндрэл, хуулиар зохицуулах шаардлагатай байгаа асуудлууд, худалдаа хөнгөвчлөх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар ярилцаж саналуудыг тусган ажилласан болно.<br><br>I хэсэг.Ерөнхий зүйл<br><br>Хуулийн зорилго, томьёоны тодорхойлолт хэсэгт буюу I-IY бүлэгт хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой асуудлыг нэмж тусгасан.<br><br>II хэсэг.Мэдээлэл, зөвлөгөө лавлагаа, гомдол<br><br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Захиргааны ерөнхий хууль, ДХБ-ын XXX-т заасан “Хэвлэл нийтлэл болон мэдээллийн хүртээмж”, “Цахим төлбөр”, “Гомдол гаргах болон гомдлыг хянан шалгах ажиллагаа”, Гаалийн бүрдүүлэлтийн горимыг уялдуулах, хялбарчлах тухай конвенцийн “Мэдээлэл технологи ашиглах”, Статистикийн тухай хууль, Нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг судалсан.<br><br>Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, гаалийн статистик, мэдээллийн технологи ашиглахтай холбогдсон харилцааг Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Мэдээллийн технологийн газраас ирүүлсэн санал, холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай уялдуулан боловсруулсан.<br><br>III хэсэг.Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, чөлөөлөх<br><br>Гаалийн тарифын тогтолцоо, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн тарифын зөвлөл, гаалийн үнэ, барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, урьдчилсан шийдвэр, гаалийн болон бусад татвар ногдуулах, төлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг тусгана. урьдчилсан шийдвэр, барааны ангилал, гаалийн үнэлгээний асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд гаалийн болон бусад татварыг төлөх баталгаа, эсхүл татварыг холбогдох дансанд байршуулан барааг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлсэн болно. | | олгох болон татвар, тарифтай итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гаалийн болон бусад татвар төлөх хугацааг уян хатан болгохтой холбогдсон бусад харилцааг нарийвчлан тусгасан.<br><br>IY хэсэг.Гаалийн хяналт, бүрдүүлэлт<br><br>Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн II-X бүлэг буюу 28-186 зүйлд гаалийн хяналт, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх, барааг мэдүүлэх, зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх онцлог, гаалийн шалгалттай холбоотой үйл ажиллагааг тусгасан.<br><br>Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн хяналт, шалгалттай холбоотой асуудлыг хуулийн төсөлд нэг бүлэг болгон нэмж тусган, хорио цээрийн хяналтын ангилал, хамрагдах бараа, тавигдах нийтлэг шаардлага, хорио цээрийн үзлэг, халдваргүйжүүлэлт, барааг буцаах зэрэг зохицуулалтуудыг ажлын хэсгийн гишүүд болон Хорио цээрийн хэлтэстэй хамтран боловсруулсан.<br><br>Гаалийн мэдүүлэг, түүний төрөл, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх, урьдчилан мэдүүлэх, мэдүүлэх хугацаа, мэдүүлэгчийн эрх, үүрэг, барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт, гаалийн мэдүүлэгт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хорио цээрийн хяналттай уялдуулан боловсруулсан.<br><br>Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдлийн мэдээлийн сан, эрсдэл тооцох үйл ажиллагааг тодорхой болгож, хорио цээрийн эрсдэлийн удирдагыг гаалийн эрсдэлийн удирдлагатай уялдуулан найруулсан болно.<br><br>Гаалийн хяналтад орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, гаалийн тэмдэглэгээ хийхэд ухаалаг ломбо ашиглах заалт, гаалийн магадлан шинжилгээнд ирүүлэх барааны тоо тэмжээг тогтоох заалт нэмж оруулсан.<br><br>Гаалийн итгэмжлэгдсэн операторын зохицуулалтыг шинээр оруулсан.<br><br>Зөвшөөрлийн тухай хуульд Гаалийн түр агуулах ажиллуулах үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан тул хуульд нийцүүлэн нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гаалийн хяналтын бүс тогтоох, сунгах, түдгэлзүүлэх, татан буулгах, Гаалийн тээвэрлэгчээр бүртгэх үйл ажиллагааг цахимд шилжүүлсэнтэй холбоотой тавигдах нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг бусад зөвшөөрөлтэй уялдуулсан.<br><br>Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбогдсон харилцааг тодорхой тусгаж, шалгалтын төрөлтэй холбоотой хэсгийг өөрчлөн найруулж, гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар гаалийн байгууллагад барааг мэдүүлээгүй, өөр бараагаар, эсхүл дутуу мэдүүлсэн зэрэг зөрчилд шийтгэл ногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш барааг гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийлгэх, бусад зөрчилд шийтгэлийн хуудсаар шийдвэрлэхээр төсөлд тусгав.<br><br>V хэсэг. Гаалийн бүрдүүлэлтийн горим<br><br>Гаалийн тухай хуулийн шинчилсэн найруулгын төслийн 189-307 дугаар зүйлд Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал, төрөл, тэдгээрийг сонгох, барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, гаалийн болон бусад татвар төлөх үүрэг үүсэх, гаалийн болон бусад татвар ногдуулах, тарифын бус хязгаарлалт, горимд байршуулахаас татгалзах, эрх шилжүүлэх, бараа, тээврийн хэрэгслийг буцаан гаргах, буцаан оруулах, гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох, гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын кодтой холбогдсон харилцааг дахин хянаж, зарим зүйл, хэсэгт найруулгын өөрчлөлт оруулсан.<br><br>Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон г захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглосон тул гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг тодорхой тусгасан, гаалийн баталгаат агуулахад тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлсон.<br><br>Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг сонон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор зохицуулсан байсан боловч УИХ-аас 2023.01.06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт баталсан Гаалийн тухай хуульд нэмэл оруулах тухай хуулийг судалж үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгохоор зохицуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэвч 2023.01.06-ны өдөр батлагдсан Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 139.1.17 заалт нэмж, татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд бүрдүүлэх бичиг баримтыг тогтоосон байна.<br>Дээрх 2 хуульд зарчмын зөрүүтэй зохицуулалт орсон тул татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох асуудлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор төсөлд найруулж, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барихаар боловсруулсан болно.<br>VI хэсэг. Гаалийн албаны тогтолцоо<br>Гаалийн албаны тодорхойлолт, тогтолцоо, удирдлага, санхүүжилт, түүний үйл ажиллагааны зарчим, гаалийн байгууллага, түүний удирдлага, алба хаагчийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон.<br>Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн болно.<br>**Биелэлт:** Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг нь Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай хуулийн гаалийн байгууллага хэрэгжүүлэн ажиллах холбогдох заалтуудыг тусган хуулийн төсөл боловсруулсан.<br>Хуулийн төсөл Ерөнхий зүйл, Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гомдол, Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, Гаалийн хяналт, бүрдүүлэлт, Гаалийн бүрдүүлэлтийн горим, Гаалийн албаны тогтолцоо зэрэг зургаан хэсгээс бүрдсэн харилцааг зохицуулсан.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Санал шийдвэрлүүлэх тухай” 01/2842 дугаар албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлэн ажиллалсан.<br>Тайлант хугацаанд<br>**1**. “Хилийн боомтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд | Биелэлт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг бүхэлд нь хасах саналтай байна.<br><br>Учир нь Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлд “хууль тогтоомж”, 2 дугаар зүйлийн 2.1-д “Монгол Улсын гаалийн хууль тогтоомж нь Үндсэн хууль,Татварын ерөнхий хууль,энэ хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Хилийн боомтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан байна.<br><br>2. 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль” гэж нэмэх.<br><br>Учир нь боомтоор мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхэд Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар энэ харилцаа зохицуулагддаг.<br><br>4. 13 дугаар зүйлийн 13.5, 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтуудыг тус тус хасах.<br><br>Учир нь эдгээр харилцаа нь Гаалийн тухай хуулиар зохицуулагдсан тул давхардсан.<br><br>5. 14 дүгээр зүйлд хил хамгаалах байгууллагын чиг үүргийг нэмж тусгаж өгөх.<br><br>Учир нь боомтоор нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтын байгууллагуудаас хил хамгаалах байгууллагын чиг үүрэг орхигдсон байгаа тухай саналыг тус хэлтсийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 99 дугаартай Боомтын хэлтэст хүргүүлсэн.<br><br>**2.** ГТЛ-с ирүүлсэн Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д заасны дагуу дотоодын гэрээгээр борлуулсныг Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолд хамааруулах эсэх, биржээр оруулахгүйгээр гаргах талаар зөвлөмж хүссэн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 60 дугаартай дотоод зурвастай танилцаж<br><br>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосны дагуу Засгийн газар батална”, 10.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” тогтоолын 223 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **2.** ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн зарим журам зааврыг шинэчлэн боловсруула х, хүчингүй болгуулах ажлын хүрээнд тус | | дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ...Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), ...даалгаж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр заажээ. Дотоод зурваст хавсаргасан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 06/2914 дүгээр албан бичгийн агуулгаас үзэхэд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиар “дотоодын зах зээлд” худалдаалсан төмрийн хүдрийг хэрхэн экспортлох талаар эрх зүйн зөвлөмж өгөөгүй байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д хүргүүлсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 06/2914 дүгээр албан бичиг нь Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27, 4.1.28, 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг хэрхэн хэрэгжүүлж ойлгохыг зөвлөснөөс бус Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолын талаар дурдаагүй байна.<br><br>Иймд уг албан бичгийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолд хамааруулан үзэх боломжгүй” гэсэн саналыг тус хэлтсийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 95 дугаартай дотоод зурвасаар өгсөн.<br><br>**3.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br><br>- Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-962.5 сая төгрөг.<br><br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/131 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.04.15-ны өдөр нээлттэй зарлан 2024.05.07-ны өдөр нээхэд Масс теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан.<br><br>Цацрагийн хяналтын төхөөрөмж шилжүүлэн суулгах засвар /Алтанбулаг, Боршоо/-306.0 сая төгрөг<br><br>Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/202 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдаг ажиллаж байна.<br><br>**Биелэлт:**<br><br>Тайлант хугацаанд бусад хууль тогтоомжид Гаалийн тухай хуулийн үзэл санааг тусгуулахаар 5 удаа санал өгч, 1 удаа Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д заасны дагуу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлтсээс захиргааны 7 шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн ажилласан.<br><br>**3.** 2023 онд ГЕГ-ын харьяа 18 гаалийн газар, хорооны дарга нарын 1220 тушаалыг хянаж 328 алдаа, зөрчил илрүүлж “Захиргааны акт хянаж, зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. | **2.** ГЕГ-ын даргын бүрэн эрхийн хүрээнд батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | дотоодын гэрээгээр борлуулсныг Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолд хамааруулах эсэх, биржээр оруулахгүйгээр гаргах талаар зөвлөмж өгч, зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-962.5 сая төгрөг, Цацрагийн хяналтын төхөөрөмж шилжүүлэн суулгах засвар /Алтанбулаг, Боршоо/-306.0 сая төгрөг байгуулах ажлын хэсэгт орж, УИХ -4, УИХ-ын байнгын хорооны тогтоол-3, Засгийн газрын тогтоол -16, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -10, Засгийн газрын албан даалгавар -2, нийт 35 тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч нийт 10 удаа гарган Сангийн яамд өгч ажилласан.<br><br>**2.** Гаалийн ерөнхий газрын дарга 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1486 тушаал баталсан бөгөөд Хуулийн хэлтсээс дээрх тушаалуудыг тухай бүр хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан. Үүнээс:<br>- А тушаал 626,<br>- Б тушаал 860 байна.<br>Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2022 оны 55 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолыг удирдлага болгон Гаалийн ерөнхий газрын даргын хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд баталсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хийж гүйцэтгэн 17 хуудас бүхий тайланг ГЕГ-ын даргын 2024.09.26-ны өдрийн №01/3943 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.Үүнд:<br>1. Захиргааны хэм хэмжээний актын үндэслэл болгосон хууль, хуулийн заалт хүчинтэй эсэх;<br>2. Хавсралтаар баталсан журам, зааврыг батлан гаргах эрх хуулиар олгогдсон эсэх;<br>3. Бусад захиргааны хэм хэмжээний акттай давхардсан, зөрчилдсөн, хууль тогтоомжид нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, зүйл, заалт байгаа эсэх;<br>4.Батлагдсан захиргааны хэм хэмжээний акт доторх зүйл, заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа эсэх, зөрчилдөж байвал хэрхэн залруулах; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Захиргааны хэм хэмжээний зүйл, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулах шаардлага, үндэслэл байгаа эсэх;<br>6.Тухайн захиргааны хэм хэмжээний акт Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй эсэх;<br>7.Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;<br>8. Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн түвшин /бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зэрэг болно.<br>Дүгнэлтийн дагуу 2024 онд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:<br>- ГЕГ-ын даргын 2016 оны “Харьяа байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай” А/83 дугаар тушаалын үндэслэл болгосон Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчингүй болсон. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023.01.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2023 оны “Согтууруулах ундааг импортлох, экспортлох хилийн боомтыг тогтоох тухай” 146 дугаар тогтоол батлагдсан. Иймд тус хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор ГЕГ-ын даргын 2016 оны “Харьяа байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай” А/83 дугаар тушаалыг хүчингүй болгож, ГЕГ-ын даргын 2023.05.08-ны өдрийн А/301 дүгээр тушаал шинэчлэгдсэн батлагдсан.<br>- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үйлчлэлийн хугацаа 2022.12.31-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан ГЕГ-ын даргын 2022.12.30-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/350 дугаар тушаалаар “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж, “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийн маягтыг хавсралтаар шинэчлэн баталж, ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийн маягтыг хүчингүй болгосон.<br>- ГЕГ-ын даргын дангаар болон хамтарсан тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах эрх хуулиар бүрэн олгогдсон байна. | |

Захиргааны хэм хэмжээний 35 актыг бусад хууль тогтоомжтой нийцэж байна гэж дүгнэсэн бол 1 эрхийн актын зарим зүйл, заалт бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Батлагдсан захиргааны хэм хэмжээний акт доторх зүйл, заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт байхгүй.

ГЕГ-ын даргын 2023 оны А/315-р тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д Авлигатай тэмцэх газрын 2024.03.19-ний өдрийн 01/4936 дугаартай албан бичгээр дээрх журмын зарим зүйл заалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэхээр байна гэсэн зөвлөмж ирүүлсний дагуу тус журмыг дахин шинэчлэн боловруулж ГЕГ-ын даргын 2024 оны “Журам батлах тухай” А/422-р тушаалаар хүчингүй болсон.

ГЕГ-ын даргын дангаар болон хамтарсан тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний акт Улсын нэгдсэн санд бүртгэгдсэн. Түүнээс **ГЕГ-ын даргын тушаалаар 6 захиргааны хэм хэмжээний** актыг хүчингүй болгох санал хүргүүлсэн, шинээр баталж шийдвэрийг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Үүнд:

| **№** | **Шийдвэрийн огноо** | **шийдвэ дугаар** | **Шийдвэр гарчиг** | **Гаальтай ...богдох зүйл, ..., эсхүл товч ...га, онцлог** |
|---|---|---|---|---|
| 1 | 20 22.12.12 | А /338 | Ш алгуур батлах тухай | “Тээв эрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур” |
| 2 | 20 22.12.12 | А /339 | Ж урам батлах тухай | “Гаал ийн хяналтын бүсийн журам”-д |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ыг хүчингүй болгосон | |
| 3 | 2022.12.14 | А/341 | Журам батлах тухай | “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих” журам | 2010 оны 388, 2014 оны А/53-р тушаалыг хүчингүй болгосон | 6082-д бүртгэсэн |
| 4 | 2023.05.08 | А/301 | Тушаал хүчингүй болгох тухай | 2016 оны "Харьяа гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай" А/83-р тушаалыг хүчингүй болгосон | 2016 оны А/83 дугаар тушаалыг хүчингүй болгосон | 4526-д бүртгэсэн |
| 5 | 2024.07.19 | А/422 | Журам шинэчлэн батлах тухай | "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам" | 2019 оны А/226, 2023 оны А/315 дугаар тушаалыг хүчингүй болгосон | 6919-д бүртгэсэн |
| 6 | 2024.07.01 | А/395 | Журам батлах тухай | Бүрдүүлэлтийн дараах шалгалтын журам | 2022 оны А/344-р тушаалыг хүчингү | 6900-д бүртгэсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | й болгос он | |

ГЕГ-ын даргын баталсан 3 захиргааны хэм хэмжээний актад оруулсан 4 нэмэлт, өөрчлөлтийн шийдвэрийг мөн нэгдсэн санд бүртгүүлсэн. Үүнд:

| № | ийдвэрийн огноо | ш ийдвэрийн дугаар | Ш ийдвэрийн гарчиг | Г аальтай холбогдох зүйл, хэсэг, эсхүл товч утга, онцлог | нэ тушаалаар хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт орсон тушаал, тушаалын заалт | Х ЗДХЯ-д бүртгэгдсэн дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 022.12.30 | А /350 | Ж урамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | “ Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт 2.2.15 дахь заалтыг нэмсүгэй. | 019 оны А/223 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулсан. А/223 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хүчин | 4 511-т хөлдөлгөөн хийсэн |

Биелэлт 100%

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | гүй болгосон | | | |
| | | | | | | 2 | 022.1 2.30 | А /351 | Ж урамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.20 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: | 019 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт оруулсан | 4 571-д хөдөлгөөн хийсэн | | |
| | | | | | | 3 | 023.0 6.05 | А /366 | Ж урамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Ж урам батлах тухай" 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Бараа устгах горим хэрэгжүүлэх журам"- | 008 оны 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулсан. | 2 985-д хөдөлгөөн хийсэн. | | |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>3. Харьяа гаалийн газар, хорооны дарга нарын бүрэн эрхийн хүрээнд батлан гаргадаг тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн</td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>ын 2.2 дахь заалтын хүснэгтийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.</td><td></td><td></td></tr>
<tr><td>4</td><td>024.06.06</td><td>А/338</td><td>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</td><td>"Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.6</td><td>019 оны А/282 дугаар тушаалд</td><td>4 571-д хөдөлгөөн хийсэн</td></tr>
</table>
Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний акт байхгүй.
Биелэлт: Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын дарга 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1486 тушаал баталсан бөгөөд Хуулийн хэлтсээс дээрх тушаалуудыг тухай бүр хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан.
Нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хийж гүйцэтгэн 17 хуудас бүхий тайланг ГЕГ-ын даргын 2024.09.26-ны өдрийн №01/3943 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
Тайлант хугацаанд захиргааны хэм хэмжээ тогтоосон 1 буюу "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д өөрчлөлт орж, 2 буюу Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам", “Бүрдүүлэлтийн дараах шалгалтын журам” тус тус шинэчилэгдэн батлагдсан.
Тайлант хугацаанд хууль хяналтын байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний акт, Гаалийн ерөнхий газрын даргын баталсан 1486 тушаалыг хүчингүй болгосон, хуульд нийцээгүй гэж дүгнээгүй болно.
</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлагаар хангасан байна. | **3.** 2024 оны эхний 11 сарын байдлаар ГЕГ-ын харьяа гаалийн газар, хорооны дарга нарын 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 01-10 дугаар сард баталсан нийт **1483** тушаалыг хянасан. Тайлант хугацаанд нийт баталсан тушаалын 93.99 хувийг ГЕГ-ын даргын 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь заалтыг үндэслэн хугацаанд нь ирүүлсэн байна. 2024 онд ГЕГ-ын харьяа 19 гаалийн газар, хорооны дарга нарын 1483 тушаалыг хянаж **217** алдаа, зөрчил (үүнээс 89 тушаал хугацаа хоцроосон) илрүүлж "Захиргааны акт хянаж, зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай" зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.<br><br>Тайлант хугацаанд нийт харьяа 18 гаалийн газар, хороодод 59 зөвлөмж хүргүүлсний дагуу 18 газар, хороо зөвлөмжийн дагуу тушаалд засвар хийж, дахин хянуулахаар 124 тушаалыг ирүүлсэн байна.<br><br>2024 онд хянуулахаар ирүүлсэн нийт тушаалын 14.63 хувь нь алдаа, зөрчилтэй байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алдаатай тушаалын **тоо 3.37** хувиар буурсан байна. Энэ нь нийтлэг батлан гаргадаг түгээмэл тушаалын үлгэрчилсэн загварыг боловсруулж харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэнтэй холбоотой гэж дүгнэж байна. Мөн нийт тушаалын 6.02 хувийг хугацаа хоцроож ирүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.08 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br><br>Тайлант хугацаанд харьяа гаалийн газар, хорооны даргын бүрэн эрхийг хэтрүүлж баталсан 5 тушаалыг хүчингүй болгуулах арга хэмжээ авч ажилласан.<br><br>Мөн 14 хоног тутмын шуурхай хуралдаанаар харьяа гаалийн газар, хороодын дарга нарт Хуулийн хэлтсээс тухай бүр зөвлөмж, зөвлөгөө өгөн ажилласан.<br><br>Мөн ГЕГ-ын Гаалийн газар, хороодын дарга нар Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/123 дугаар тушаалын хавсралтаар тухайн Гаалийн газар, хорооны зохион байгуулалтын бүтэц орон тоонд батлагдсан байнгын болон улирлын шинжтэй төрийн үйлчилгээний албан хаагчийг ажилд томилох тушаал батлан гаргахдаа төрийн үйлчилгээний албан хаагчийн хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлүүдийг олгох ёстой.<br><br>Харин тухайн Гаалийн газар, хорооноос гэрээгээр ажиллуулахаар гэрээт ажилтныг ажилд томилох тушаал батлан гаргахдаа цалин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөлсийг Хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах учраас төрийн үйлчилгээний албан хаагчийн бусад нэмэгдлүүдийг олгохгүй байх.<br><br>Иймд Гаалийн ерөнхий газрын харьяа Гаалийн газар, хороодын дарга, албан хаагч нар дээрх зөвлөмж, чиглэлийн мөрдөж ажиллах талаар харьяа гаалийн 19 газар, хороодын дарга нарт ГЕГ-ын №01-1.2/4949 албан бичгээр зөвлөмж чиглэл хүргүүлэв. /Жагсаалт хавсаргав/ | |
| 2 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагаатай холбоотой, давхардсан тоогоор нийт 62 хуулийн жагсаалтыг үүсгэсэн бөгөөд Гаалийн байгууллагы | **1.** Гаалийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг холбогдох ЗББН-ээс гаргуулан авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна. | **1.** Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан 35 эрхийн акт бүхэлдээ, эсхүл зарим зүйл заалт нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт тухайн харилцааг зохицуулж чадаж буй эсэхийг тодорхойлох, давхардал, хийдлийг арилгаж, эрх зүйн актын зөрчилгүй сан үүсгэх зорилгоор хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн.<br><br>Шинжилгээний ажлын үр дүнгээр дараах санал зөвлөмжийг гарч байна. Үүнд:<br><br>- Зөвхөн гаалийн албаны үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх шинжтэй шийдвэр хэрэгжилтийг хангаж ажиллах төдийгүй Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, бусад хөтөлбөр зэрэг гүйцэтгэх засаглалын байгууллагаас баталж байгаа бодлогын баримт бичгийг тухай бүр судалж, тэдгээрт тусгагдсан арга хэмжээнд эрхлэх асуудлын хүрээнд гаалийн удирдах төв байгууллагаас боловсруулах санал, дүгнэлт, зөвлөмж, зөвлөгөө, судалгаа, шийдвэрийн төслийг боловсруулан батлуулахдаа холбогдох эрх зүйн зохицуулалтыг давхардуулан батлахгүй байх.<br><br>-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний дагуу Ерөнхий сайд, Засгийн газрын хуралдаан, Сангийн яам, Гаалийн ерөнхий газрын даргаас Гаалийн ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний 35 актыг цөөлөх хүчингүй болгох арга хэмжээг зохион байгуулах ажлыг үүрэг болгосон. Үүнтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан эрхийн актуудыг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах 13 эрхийн актын төслийг боловсруулж, олон нийтээс санал авч хэлэлцүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.<br><br>- ГЕГ-ын даргын тушаалаар нийтээр дагаж мөрдөхөөр батлагдсан эрхийн актыг тухай бүрт нь Захиргааны ерөнхий хуулийн 64 зүйлийн 64.4 дэх хэсэг “Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.” Гэж заасны дагуу Захиргааны хэм хэмжээний | Биелэлт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ | Үйл ажиллагаа | | н зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд хамаарах хуулиудын хэрэгжилтийн биелэлтийг гаргуулан авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2023 оны хагас жилийн тайланг СЯ-ны ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд цахим хаягаар 2023.06.27-ны өдөр хүргүүлсэн.<br><br>2.УИХ-ын тогтоол 4, ҮАБ-ын зөвлөмж 1, ЗГ-ын тогтоол 16, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 8, ЗГ-ын албан даалгавар 2, нийт 31 тогтоол шийдвэрийн | **2.** УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх. | актын улсын нэгдсэн бүртгэлд шинээр бүртгүүлэх, холбогдох хөдөлгөөнийг хийлгэх гэсэн санал зөвлөмж гарсан.<br><br>Уг ажлын тайланг Сангийн яаманд танилцуулахад бэлэн болсон болсон бөгөөд Сангийн яамны зүгээс “Гаалийн ерөнхий газрыг дуудах хүртэл түр хүлээж бай” гэсэн чиглэл өгсөн. Үнэлгээний тайланг хавсаргав.<br><br>**Биелэлт:** Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүдээс санал авч Монгол Улсын Сангийн яамны “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн №03/7707 албан бичгийг үндэслэн ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт болох нийт 35 эрхийн актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайланг нэгтгэж Гаалийн ерөнхий газрын удирдлагад 2024.10.02-ны өдөр танилцуулсан. Сангийн яам дуудан ирүүлэхэд танилцуулахад бэлэн болсон.<br><br>**2.** Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дугаар тушаалаар Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтад өөрчлөлт орж Хуулийн хэлтсийн чиг үүрэгт “УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх” арга хэмжээ 2023 оны 03 дугаар сараас нэмэгдсэн. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус журмын нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа”-г тус тус үндэслэн тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна. Тус ажлын хүрээнд ГЕГ-т хамаарах тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Сангийн яаманд хүргүүлэн ажилаж байна.<br><br>Тайлант хугацаанд ГЕГ-ын бүтцийн нэгжүүд буюу 10 нэгжээс шаардлагатай биелэлтийг авч дараах тогтоол шийдвэрийн тайланг гаргаж ажилласан. Үүнд: | Биелэлт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
